Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А.Д.Х.Гүйцэтгэх захиргааны сонин.

18 дахь жилдээ
№ 56(1457)

1965 оны
7 дугаар сарын 26

ДАВАА

# Социалист уралдааныг өрнүүлье

Социалист нийгмийн үйлдвэрлэлийг хөдөлгөгч хүч, үй олон түмнийг бүтээлч тэмцэлд дайчлагч хэрэглүүр болсон социалист уралдаан шинэ шинэ хэлбэрүүдээр баяжин, олон түмэнд нөлөөлөх хүч чадал нь улам бүр нэмэгдэж, түүний шинэ дээд хэлбэр социалист хөдөлмөрийн төлөө, шинийг санаачлагчдын хөдөлгөөн тус аймгийн улс ардын аж ахуйн салбарт эрчимтэй өрнөлөө.

Одоо аймгийн хэмжээгээр социалист уралдаанд 20 гаруй үйлдвэр, аж ахуйн газар, 30 шахам цех тасаг, 5300 гаруй хүмүүс хамрагдаж байгаагийн дотор ажилчин албан хаагчид 95,8 хувийг нь эзлэж байна.

Аймгийн хүнсний комбинат, Өндөрширээт,Баянжаргалан сумд социалист уралдааныг тодорхой удирдаж. улс аймгаас өгсөн төлөвлөгөөт даалгавар, уралдааны үүрэг зорилтыг хөдөлмөрчин олонд таниулж социалист уралдаанд ажилчин, малчин, цех тасаг бригадуудыг хамруулан тэднээр үүрэг амлалт авахуулж социалист уралдаанд оролцогчидтой тодорхой ажиллаж тэдгээрийн амжилт, арга туршлагыг ханын самбар үзүүлэлтээр сурталчлаж ажлаараа хоцорч яваа хэсгийг өөд татахад уралдааны олон хэлбэрийг ашигладагаас 1965 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг эдийн засгийн үзүүлэлт бүрээр нь биелүүлж социалист уралдаанд бусдаасаа түрүүлж аймгийн Намын хороо, АДХ—ын Гүйцэтгэх захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн зөвлөлийн социалист уралдааны шагнал авсан билээ.

Мөн социалист уралдаанд оролцогчдын дотроос Батсүмбэрийн САА—н ногоочин Должинжав, Гачууртын САА—н саальчин Цэндээхүү, Угтаалын САА—н тракторч Алтанхүү нарын зэрэг олон арван малчин, саальчин, ногоочин, тракторч тэргүүний хүмүүс мэргэжил нэгтэй нөхөддөө социалист уралдаанд уриалан үүрэг амлалт авч ажиллаад авсан үүргээ нэр төртэй биелүүлж байна.

Түүнчлэн тус аймагт социалист уралдааны шинэ дээд хэлбэр, социалист хөдөлмөрийн төлөө хөдөлгөөн өрнөн тэдгээрийн үйл ажиллагаанд чанарын их өөрчлөлт гарч зөвхөн үйлдвэр аж ахуй, соёл үйлчилгээний газруудын хэмжээгээр СХ Бригад, 60—аад, СХТ Бригад 130 гаруй С С нөхөрлөл 50 шахам, СХТ үйлдвэр 3—тай болж энэ хөдөлгөөнд 3000—аад хүн буюу ажилчин албан хаагчдын 5,2 хувь нь хамрагдаж байна.

Социалист уралдаан нь хөдөлмөрчин олны идэвх санаачлагыг ихэд өрнүүлэн нийгмийн үйлдвэрлэлийн тасралтгүй өсөлтийг ханган социализм коммунизм байгуулах арга юм.

Гэтэл социалист уралдааны бүтээлч дайчлагч үүргийг дээшлүүлж үй олныг үйлдвэрлэлийн төлөвлөгөө биелүүлэх тэмцэлд дайчлахаар далайцтай зохион байгуулахгүй түүнд ёс төдий хандлаг ноцтой дутагдал үзэгдсээр байна. Социалист уралдаанд газар бүр материаллаг үйлдвэрийн хүрээн дэх ажилчдыг бүрэн хамруулах, ялангуяа шинэ ажилчид, туршлага багатай хүмүүсийг хөдөлмөрч эвсэг, өндөр ухамсартай болгон хүмүүжүүлэх ажлыг шаардлагын хэмжээнд хүртэл зохион байгуулахгүй байна.

Мөн ажлаараа хоцорч яваа байгууллага хүмүүсийг өөд татахад социалист уралдааныг шууд чиглүүлэхгүй байгаагаас уралдаан нь тэргүүний хэсэг хүмүүсийн дотор хязгаарлагдаад ажлын шилдэг арга туршлагад бусад ажилчдыг сургах зэвсэг болж чадахгүй байна.

Уралдааныг зохих хугацаанд нь дүгнэн түүнд оролцогчдын үйл ажиллагааг нийтийн өмнө хэлж өгөхгүй зөвхөн суурь эзлэгчдэд шагнал олгохоос хэтрэхгүй байна. Аймгийн барилга монтажийн конторын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо социалист уралдааныг доороос өрнүүлэх ажлыг хангалтгүй зохиож зөвхөн дээрээс нь уралдааны ганц нэг болзол зарлах, ёс төдий үүрэг солилцсоноор ажлаа хязгаарлаж уралдааныг жинхэнэ ажил хэрэгчээр зохион улсын төлөвлөгөөг нэр төрөл тоо чанараар нь давуулан биелүүлэхэд чиглүүлэн удирдаж чадаагүйгээс 1965 оны эхний хагас жилийн барилга угсралтын төлөвлөгөөг тасалдуулсан билээ.

Иймд аймгийн улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг жигд давуулан биелүүлэх, бүтээгдэхүүний чанар үзэмжийг сайжруулж, өөрийн өртгийг хямдруулж арвилан хэмнэлт, ашигт ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлж шинэ бүгээл оновчтой санал гаргах тэргүүн туршлагыг дэлгэрүүлэн эзэмшихэд бүтээлч олны хүчийг социалист уралдаанаар эрчимжүүлэх нь чухал байна.



## Өндөр ургац даллаж байна

## Сурталчлан туслах бригад яаж ажиллах вэ?

Жил бүрийн намар цаг манай сайхан эх орны уудам тал, хөндийд өтгөн их хадлан, арвин элбэг тариа будааг бэлтгэх, хураах өрнүүн хөдөлмөр буцалсан үе байдаг билээ.

Хадлан авах, тариа хураах ажил нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа хүмүүсийн үүрэг төдий биш,бүх нийтийн хэрэг мөн.

Энэ учраас манай үзэл суртал, соёлын байгууллагууд, клуб, соёлын орднууд хадлан тариа хураалтын үед тодорхой зорилттой ажиллах үүрэгтэй.

Тэд улсын төлөвлөгөөт даалгаварыг биелүүлэхэд хүмүүсийг идэвхжүүлэх, ажлын дэвшилттэй арга барилыг батагтан нийтийн хүртээл болгох, цаг хугацаа алдан залгайрах, ажилд саад болж хоцрогсодыг шүүмжилж, тэднийг сайчуудын эгнээнд хүргэх, техник ашиглалт, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор улс, төр, соёл хүмүүжлийн олон хэлбэрт ажил зохиох ёстой-

Эдгээрийн дотроос сурталчлан туслах бригад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сурталчлан туслах бригад нь бүрэлдэхүүний хувьд лектор буюу ухуулагч, хөгжимчин, эмч, тогооч, үсчин, гуталчин, зурагчин, кино механикчийн бүрэлдүүнтэй байх нь ашигтай.

Бригадыг бэлтгэн гаргахдаа түшиглэсэн намын байгууллагын удирдамжийн дагуу зохих холбогдох худалдаа үйлчилгээ, эмнэлэг залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран өөрийн боломж нөхцөлийг бодолцон төлөвлөгөө зохиох хэрэгтэй.

Төлөвлөгөөнд орох гол зүйлс:

1. Хэднээс хэдэн хүртэл хаагуур явах замыг тодорхойлох
2. Ямар ямар сэдвээр яриа таниулга хийх.
3. Соёл урлаг, үйлчилгээний ямар хэлбэрүүдээр үйлчлэх.
4. ХАА—н сэдвээр хэдэн төрлийн ямар самбар ухуулах хуудас гаргах, мөн өөрийн аж ахуйн амьдралаас хэн хэний туршлагыг ямар хэлбэрээр сурталчлах зэргийг оруулах нь зүйтэй.

Бригадын хадлан, тариа, ногооны тасаг мал аж ахуйн бригад хэсэг, фермүүдийн ажлын талбайд нь очиж үйлчлэх хэрэгтэй.

Өөрийн ажлыг хөнгөвчилж хэд хэдэн бригад тасгийг нэг дор бөөгнөрүүлж байж ажлаа зохиох гэж хүмүүст чирэгдэл учруулж болохгүй. Өөрөөр хэлбэл хамрагдах хүмүүсийн тооны хойноос хөөцөлдөхгүй цөөн хүнд ч гэсэн чанартай ажил зохиох хэрэгтэй.

Сурталчлан туслах бригадууд ухуулга таниулгын ажилдаа заавал лекцийн суртал нэвтрүүлгийн хэлбэрийг ашиглахгүй яриа үзүүлэн, айрагны үдэшлэг, аман сэтгүүл, гэрэлт сонин гаргах, сангийн аж ахуй нэгдлийн төвөөс зайдуу бригад буюу хэсгээр ажиллаж байгаа хүмүүст эмч, үсчин, гуталчин, зурагчнаар үйлчлэх,бас зарим үедамт чанар сайтай хоол хийж өгч туслах зэргээр хүмүүст үнэхээр тус хүргэхүйцээр ажиллах хэрэгтэй.

Жишээ нь сангийн аж ахуйн тариа хураах комбайны нэг бригад дээр сурталчлан туслахаар очиж гэж үзье.

Тэгвэл юуны түрүүнд уг бригадынхны ажилтай тодорхой танилцаж өөрсдийн зохиох яриа ухуулгын ажлыг баяжуулах хэрэгтэй.

Тэгэхдээ яриа ухуулга нь уг ажиллаж байгаа комбайнчтай харилцан ярилцаж асуух хариулах замаар явагдах нь ашигтай.

Сурталчлан туслах бригад ажлын өдрийн дараагаар айрагны үдэшлэг зохиох нь ухуулга зугаалгыг хослуулах соёл олон түмний ажлын сонирхолтой хэлбэрийн нэг юм.Энэ үдэшлэгийг 3—4 хүнтэйч, 30—40 хүнтэй ч зохиож болно.

Тэгэхдээ үдэшлэгийг САА—н нам захиргаа, үйлдвэрчин, залуучуудын эвлэлийн байгууллагуудтай хамтран сайн ажиллаж байгаа бригад хүмүүст зориулж явуулах хэрэгтэй. Үдэшлэг дээр сайхан айраг ууж өөрсдийн ажлын тухай илэн далангүй ярилцах, бригадын хөгжимчин, дуучин, үдэшлэгт оролцогчдын захиалгаар дуулж хөгжимдөж өгөх, үйлдвэрчний эвлэлийн хороо уралдааны дүнг гарган баярын бичиг, ном, шилжин явах дарцаг гардуулж урамшуулах, соронзон хальсанд бичигдсэн дуу хөгжим сонсгох, харилцан үг хэлж үүрэг авах ажлуудыг зохиох ёстой. Үүнээс гадна сурталчлан туслах бригад нь сайн муу ажиллагааг зэрэгцүүлэн үзүүлсэн мэдээлэх хуудас, цахилгаан сонин гаргахаас гадна, хадлан, тарианы хураалтын ажлын тэргүүний туршлагыг бригадын явцад ба цаашид төв,орон нутгийн хэвлэлд бичиж радиогоор уншиж өргөн сурталчлах нь чухал. Киногоор үйлчлэх явдал сурталчлах бригадын нэг гол үүрэг мөн. Тэдний авч явах кино бүлэг цөөнтэй. уран сайхны буюу өөрийн эх орны болон социалист орнуудын ХАА—н тэргүүний туршлагыг харуулсан баримтат кинонууд байвал сайн.

Урьд хадлан, тариа хураалтын үеэр,орон нутгаас зохион гаргаж байсан бригадууд олон жүжигчид хамарсан концерт,жүжиг бүхий урлагийн бригадын хэлбэрээр зохиогдож голдуу хүн ам олонтой суурин газруудаар аялан жинхэнэ хадлан, тарианы талбай дээр очихгүй бригадын төвд ирээд явсан гэнэ гэдэг сураг сонсогдоод өнгөрдөг байсан муу заншлыг арилгах хэрэгтэй.